

ТӨВ АЙМГИЙН БҮРЭН СУМЫН БАЯР НААДМЫН ТАЛБАЙН НЭМЭЛТ АЖЛЫН
ДААЛГАВАР

1. Баяр наадмын талбайн нэмэлт ажлыг дараах Барилгын норм ба дүрэм /БНБД/ стандартыг баримтлан технологийн дагуу чанартай гүйцэтгэх.
2. Ажил гүйцэтгэх хугацааны график /хөдөлмөр зориулалт, үргэлжлэх хугацаа, ажиллах хүчний тоо/-ийг тодорхой гаргаж ирүүлнэ. Мөн ажлыг гүйцэтгэх технологи аргачлал, техникийн тодорхойлолтыг боловсруулж ирүүлнэ.
3. Үнийн саналд баяр наадмын талбайн нэмэлт ажлын тооцоог Барилгын төсөв зохиох дүрэм БНБД 81-95-12*2020-г тооцож ирүүлнэ.
4. Үнийн тарифыг тооцон ирүүлэхдээ ажилбар тус бүрээр тооцож ирүүлнэ.
5. Нэмэлт ажлыг 06 дугаар сард багтаан гүйцэтгэнэ.

1. Үзэгчдийн суудлын ажил

Хойд төв асар болон 2 хажуу талын туслах асар түүнээс хойших 74 метр газарт 3 эгнээ үзэгчид суух зориулалтын сандалыг квадрат төмрөөр рам зангидаж хятад улсад үйлдвэрлэгдсэн хуванцар 200 ширхэг сандалыг шинээр авч суурьлуулна. Рам хэсгийг зангидах квадрат төмөр нь 40*60 хэмжээтэй хананы зузаан 2,5 мм-ээс багагүй газрын хөрсөнд 40 см-ийн гүнд суулгана. 3 эгнээ сандал дээр тавигдах банз нь 3-5 см зузаантай байна.

Сандалаас дээш хэсэгт 74 метр газарт квадрат төмрөөр рам зангидан сүүдрэвч хийнэ.

2. Гэрийн буйр цутгах ажил

Гэрийн буйрыг төв асраас хойш 20 метрийн зайд газрын хөрсийг суллан 10*30 хэмжээтэй 40 см зузаантай цутгаж өнгөлгөө хийнэ. Гэрийн буйр төв асрын хоорондох 20 метрт бетон цутгаж өнгөлгөө хийнэ. Цутгамал бетоныг стандарт норм дүрмийн дагуу хайрга цементийг хийж бетон хучилтын ажлыг хийнэ.

Суурийн хөрсийг ухсан шороог зөөвөрлөж асгах өвлийн улиралд газар хөлдсөнөөс үүдэн хөрс нь ихээр овойлт үүсдэг тул ажил гүйцэтгэгч бүрэн хариуцна.

Тугний суурь

Баяр наадмын талбайн тугний суурь

Тугний суурийг бетон цутгаж гадна талыг некэлээр өнгөлөн тугний иш 5 метртэй никель төмөр байхаар тендерийн материалд ирүүлнэ.

Нийтийн бие засах газар

Нийтийн бие засах газрыг төв талбайгаас зүүн урагш 400 метр зайд байхаар төлөвлөж нүхийг газрын хөрснөөс доош 4 метр ухаж нүхний дотор талыг блок болон 5 см-ын зузаан банзаар доторлоно. Нийтийн бие засах газар дотроо 3 ширхэг суултуур, 2 шээлтүүртэй байна. Бие засах газрын бүхээг нь 20*40 квадрат төмрөөр рам хэсгийг зангидаж 3 хаалга 3 кабинтой, гадна хэсгийг сайтынг ашиглан өнгөлж дотор талыг хөөс болон хар панериар доторлож агааржуулалтын хоолой дээш гаргана.


Морь барианы хашаа шинэчлэх

Морь барианы зам дагуу 250 метр хашааг засаж янзлах болон эвдрэл гарсан засах шаардлагатай 100 метр хашааг төмөр тороор засаж сэлбэн дээд хэсэгт 15 угольник төмрөөр гагнуур хийж бэхэлнэ.

Гэрэлтүүлгийн ажил

Наадмын талбайн стадионыг тойруулан 9 метр өндөртэй 220W цахилгаанаар тэжээгдэх 100w-ийн 6 ширхэг гэрэлтүүлгийг сиб кабелиар холбон хүчдэлд холбоход бэлэн байхаар ажлыг гүйцэтгэнэ. Гэрэлтүүлгийн шон нь гэрлийн шонд зориулан бэлтгэгдсэн доод хэсгээс дээш нарийссан стандартын шон байна. Гэрэлтүүлгийн шонг газрын хөрснөөс доош 60 см-т суулгана.

АЖЛЫН ДААЛГАВАР БОЛОВСРУУЛСАН:

ТӨХӨМ /1-Р/ БАГИЙН ЗАСАГ ДАРГА  Ц.ЛХАГВА